

**ОЛОН НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮЕИЙН
ЦАГДАА, ДОТООДЫН ЦЭРГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ
ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ
DURING PUBLIC SAFETY COOPERATION BETWEEN
POLICE AND INTERIOR MILITARY
LEGAL REGULATION**

Б.Баянмөнх
ДХИС-ийн ЦС-ийн ЦЭЗТ-ийн дэд профессор,
доктор (Ph.D), цагдаагийн дэд хурандаа
Дотоод хэргийн их сургууль,
Монгол Улс Цахим шуудан:
bayanmunkh@uia.gov.mn

B. Bayanmunkh
Associate Professor at the Department
of Police Law, University of Internal Affairs
Doctor of Law (Ph. D),
Police Lieutenant Colonel
University of Internal Affairs
State Email: bayanmunkh@uia.gov.mn

Хураангуй. Өнөөдөр дэлхийн улс орнуудад ган, зуд, аадар бороо, мөндөр, хүчтэй цасан шуурга, үер зэрэг байгалийн аюулт үзэгдлийн давтамж, эрчим эрс нэмэгдэж, улмаар хүн амь насаа алдах, улс орны эдийн засагт учруулсан хохирлын хэмжээ сүүлийн 20 гаруй жилд 2 дахин нэмэгдсэнийг судлаач мэргэжилтнүүд тогтоосон байдаг. Үүнтэй зэрэгцээ дэлхий дахины улс төрийн бодлоготой холбоотойгоор террорист халдлага улам нэмэгдэх хандлагатай болж байгаа нь улс орон бүрийн анхаарах асуудал болоод байна.

Энэхүү өгүүлэлд олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий цагдаа, дотоодын цэргийн хамтын ажиллагааны эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдлыг судалж, харилцан хамтын ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг сайжруулахад чиглэлээр өөрийн санаа бодлоо товч бичсэн болно.

Summary. Today, in countries around the world, the frequency and intensity of natural hazards such as drought, drought, heavy rain, hail, heavy snow storms, and floods have increased dramatically, resulting in the loss of lives and the amount of damage caused to the country's economy has doubled in the last 20 years. is established. At the same time, the trend of increasing terrorist attacks due to global political policies has become a concern of every country.

This article examines the current state of legal regulation of police and domestic military cooperation with the function of ensuring public safety, and briefly writes his opinions and conclusions on whether mutual cooperation is fully regulated.

Түлхүүр үг. Цагдаа, дотоодын цэрэг, хамтын ажиллагаа, эрх зүйн зохицуулалт, эрх, үүрэг

Key word. Police, internal military, cooperation, legal regulation, rights and duties

Үндсэн хэсэг. Төрийн анхдагч үүрэг бол хувь хүний амь нас, эрх чөлөө, эд хөрөнгийг хамгаалах явдал юм. Хамгаална гэдэг нь аюулгүй байх нөхцөлийг бүрдүүлэх, улмаар болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэхийг ойлгоно.

Энэ үүргээ биелүүлэхийн тулд нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон хууль тогтоомж гаргаж, түүнийг хүн бүрээр сахиулж мөрдүүлэх, хэрэгтэй бол хүч хэрэглэх онцгой эрх эдэлдэг. Харин иргэд аюулгүй байдлаа хангуулахын тулд татвар төлдөг. Төр бас иргэдийн нэрийн өмнөөс төлбөр, хураамж цуглуулж, үйл ажиллагааны зардлаа нөхдөг.

Аюулгүй байдлыг хангах энэхүү онцгой үүргийг хүлээсэн төр нь шүүх, цэрэг, цагдаа гэх мэт институцуудыг ажиллуулах замаар онцгой эрхээ эдэлдэг.¹

Аюул занал бол яг таг тодорхойлж болдог ойлголт биш бөгөөд байнга өөрчлөгдөж байдаг, энэ ойлголтыг янз бүрийн утгаар хэрэглэдэг байна. Гэхдээ аюул заналыг цаг ямагт явцуу утгаар ойлгож, мэдэгдэм бодит шинжтэй болгон ойлгож ирсэн уламжлал амь бөхтэй оршсоор иржээ.

Улс орны дотоод аюулгүй байдлыг хангах үүрэгтэй цагдаа, дотоодын цэргийн байгууллага нь болзошгүй аюул заналаас ард иргэдээ хамгаалах, болзошгүй аюулыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх үүргийг тус тус хуульд тусгаж өгсөн байдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн 11.1-д заасан “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн”² гэж заасан нь Засгийн газрын тохируулагч агентлагын хувьд цагдаагийн байгууллага болон Дотоодын цэргийн байгууллагын нэг үүрэг болохын хувьд олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндэс болно.

“Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хууль”-ийн 3.4.3-д заасан “иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдал”-ыг хангах нь цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны нэг үндэс болно. Учир нь уг хуулийн 7.1-д заасан Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын 7.1.11. “цагдаагийн алба”³ гэж заасан билээ.

Цагдаагийн албаны тухай хуулийн 4.1. “Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгай алба мөн”⁴ гэж заасан байдаг.

ЦЕГ-ын даргын 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/246 дугаар тушаалаар батлагдсан “Цагдаагийн байгууллагын чиг үүрэг, эрх хэмжээг тодорхойлох журам” /код 100/-ын 100.22 /хавсралт/-д Дотоодын цэргийн штаб нь “Улсын онц чухал объектыг хамгаалах, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргийг таслан зогсоох, гамшиг, аюулт үзэгдэл, осол аюул тохиолдсон үед болон эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, шаардлагатай үед зарим объектыг түр хугацаагаар хамгаалах, зорчигч, ачаа тээшийг харгалзан хүргэх, террорист үйлдлийг таслан зогсоох, тусгай ажиллагаанд оролцох”⁵ гэж заасан байдаг.

¹ Баянмөнх Б. Цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа. УБ.2018. 7 дахь тал

² Төрийн мэдээлэл. 1992. №1. Монгол Улсын Үндсэн хууль

³ Төрийн мэдээлэл.2002. №3. Үндэсний аюулгүй байдлын тухай хууль

⁴ Төрийн мэдээлэл. 2017. №6. Цагдаагийн албаны тухай хууль

⁵ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. УБ.2018. 29 дэх тал

Дотоодын цэргийн тухай хуулийн 2 дугаар зүйл /Дотоодын цэргийн хууль тогтоомж/-ийн 2.1.Дотоодын цэргийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Цэргийн албаны тухай хууль, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжоос бүрдэнэ.⁶

Цагдаа, дотоодын цэргийн харилцан хамтын ажиллагааг зохицуулсан эрх зүйн зохицуулалтыг Дотоодын цэргийн тухай хуульд хэрхэн тусгасныг хүснэгтээр авч үзвэл:

Хүснэгт №1

№	Зүйл	Хэсэг
1.	7 дугаар зүйл. Дотоодын цэргийн бүтэц, удирдлага	7.2.Цагдаагийн төв байгууллагын дарга нь дотоодын цэргийн командлагч байна.
2.	8 дугаар зүйл. Дотоодын цэргийн командлагчийн бүрэн эрх	8.1.3.цагдаагийн байгууллагатай харилцан ажиллах удирдамж, төлөвлөгөөг батлах;
3.	12 дугаар зүйл. Улсын онц чухал объектыг хамгаалах	12.1.4.хамгаалалтад байгаа объектод хууль бусаар нэвтэрсэн этгээдийг мөрдөн хөөх, саатуулах, цагдаагийн байгууллагад хүргэх;
4.		12.2.Хамгаалж байгаа объектын хэвийн үйл ажиллагаа алдагдсан, зөрчил илэрсэн үед объектын захиргаа, нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага болон бусад анги, салбартай мэдээлэл солилцох, тэдгээрийн хүч хэрэгслийг ашиглах, объектийн онцлогт тохирсон шалган нэвтрүүлэх журмыг анги, салбарын захирагч холбогдох байгууллагатай зөвшилцөн тогтооно.
5.	13 дугаар зүйл. Нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргийг таслан зогсооход дэмжлэг үзүүлэх	13.1.Цагдаагийн байгууллагаас хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд хүч хэрэгсэл хүрэлцэхгүй тохиолдолд цагдаагийн байгууллагад дэмжлэг үзүүлэх зорилгоор дотоодын цэрэг дараахь үүргийг гүйцэтгэнэ: 13.1.1.баяр наадам, жагсаал, цуглаан зэрэг нийтийг хамарсан арга хэмжээний үед нийтийн хэв журмыг сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах;
6.		13.1.2.гудамж, талбай зэрэг олон нийтийн газарт үүссэн нийтийг хамарсан эмх замбараагүй байдлыг таслан зогсоох, иргэний болон төрийн байгууллагын аюулгүй байдал, өмч хөрөнгийг хамгаалах;
7.		13.1.3.гяндан, чанга, онцгой дэглэмтэй хорих анги, цагдан хорих байранд үймээн гарсан үед дэг журам тогтоох;
8.		13.1.4.хорих ангиас оргон зайлсан гэмт этгээдийг баривчлах, сураггүй алга болсон этгээдийг эрж олох талаар цагдаагийн болон хорих байгууллагаас явуулж байгаа нэгдсэн арга хэмжээнд оролцох;
9.		13.1.5.шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах;
10.		13.1.6.гэрч, хохирогчийг хамгаалах;
11.		13.1.7.сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтныг хуяглан хүргэх;
12.		13.1.8.шаардлагатай тохиолдолд хууль тогтоомжоор болон эрх бүхий байгууллагаас тогтоосон нийтээр дагаж мөрдөх журмыг сахиулах зорилгоор явуулж байгаа цагдаагийн байгууллагын эргүүлийн үйл ажиллагаанд оролцох.
13.		13.2.Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргийг таслан зогсоох ажиллагаанд оролцох удирдамж, төлөвлөгөөг дотоодын цэргийн командлагч батална.
14.	14 дүгээр зүйл. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд болон хорио цээрийн дэглэмийг сахиулахад оролцох	14.1.6.гэмт хэрэг, зөрчлийн ул мөр, нотлох баримтыг хадгалах, хамгаалах арга хэмжээ авах, гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдийг саатуулах, цагдаагийн байгууллагад хүргэх;
15.	16 дугаар зүйл. Террорист үйлдлийг таслан зогсоох тусгай ажиллагаанд оролцох	16.1.Дотоодын цэрэг нь цагдаагийн байгууллагатай хамтран террорист үйлдлийг таслан зогсоох тусгай ажиллагааны бүсийг хамгаалалтад авах, тухайн бүсэд байгаа иргэний амь нас, эрүүл мэндийг авран хамгаалах, гэмт этгээдийг олж тогтоох, аюулгүй болгох, баривчлах

⁶ Төрийн мэдээлэл. 2017. №12. Дотоодын цэргийн тухай хууль

		үүргийг гүйцэтгэнэ.
16.	33 дугаар зүйл. Дотоодын цэргийн алба хаагчийн эрх	33.1.2.энэ хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор иргэн, хуулийн этгээдэд хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актаар тогтоосон дүрэм, журмыг биелүүлэх, хууль бус үйлдлээ таслан зогсоох талаар шаардлага тавих, гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдийг түр саатуулах, түүнийг цагдаагийн байгууллага, албан тушаалтанд шилжүүлэх;
17.		33.1.3.хамгаалж байгаа объектод халдсан, хууль бусаар нэвтрэн орохыг завдсан этгээдийг мөрдөн хөөх, түр саатуулах, цагдаагийн байгууллага, албан тушаалтанд шилжүүлэх;
18.		33.1.6.нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын даргын шийдвэрээр хамгаалалтад байгаа объектод хууль бусаар нэвтэрсэн этгээдийг олж тогтоох, халдлага, гэнэтийн аюул, ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор хамгаалалтад байгаа объектыг бүслэн хаах, уг бүсэд байгаа иргэний бичиг баримтыг шалгах, эд зүйлд үзлэг хийх;
19.		33.1.9.энэ хуулийн 11.1.2-д заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ Цагдаагийн албаны тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу хүний бичиг баримтыг шалгах;
20.		33.1.10.хамгаалалтад байгаа объектын ойр орчимд илэрсэн сэжиг бүхий хүн, тээврийн хэрэгслийн бичиг баримтыг шалгах, илэрсэн зөрчлийг цагдаагийн байгууллагад шалгуулахаар шилжүүлэх;
21.	38 дугаар зүйл. Дотоодын цэргийн санхүүжилт	38.2.Дотоодын цэргийн санхүүжилт, аж ахуй, материал-техникийн хангалтыг цагдаагийн төв байгууллага хариуцна. ⁷

Дээрхи хүснэгтэд заасан зохицуулалтыг үзвэл Дотоодын цэргийн тухай хуульд цагдаа, дотоодын цэргийн харилцан, хамтын ажиллагааг тусгасан 8 зүйл, 21 хэсэгт тусгасан байна. Эдгээр зохицуулалтууд нь дараах харилцааг зохицуулжээ. Тухайлбал:

- Дээд удирдлагын түвшинд шийдвэр гаргах албан тушаалтан нэг болохыг тусгасан
- Цагдаа, дотоодын цэргийн байгууллага харилцан ажиллах удирдамж, төлөвлөгөөг батлах;
- Объектын хамгаалалт, түүнийг хууль бусаар нэвтэрсэн этгээдийг цагдаагийн байгууллагад хүргэх
- Хамгаалалтын хэвийн байдал алдагдсан тохиолдолд нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагатай мэдээлэл солилцох
- Цагдаагийн байгууллагаас хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд хүч хэрэгсэл хүрэлцэхгүй тохиолдолд цагдаагийн байгууллагад дэмжлэг үзүүлэх
- Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргийг таслан зогсоох ажиллагаанд оролцох удирдамж, төлөвлөгөөтэй байх
- Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд болон хорио цээрийн дэглэмийг сахиулахад хамтран оролцох
- Террорист үйлдлийг таслан зогсоох тусгай ажиллагаанд хамтран оролцох
- Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын даргын шийдвэрээр нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах тодорхой ажиллагаанд хамтран оролцох
- Цагдаагийн төв байгууллага хамтын ажиллагаатай холбоотой санхүүжилт, аж ахуй, материал-техникийн хангалтыг хариуцах гэх мэт харилцааны эрх зүйн үндсийг тус тус тодорхойлжээ.

Харин цагдаа, дотоодын цэргийн харилцан, хамтын ажиллагааны талаар Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд дараах зохицуулалтууд тусгагдсан байна. Тухайлбал:

⁷ Төрийн мэдээлэл. 2017. №12. Дотоодын цэргийн тухай хууль

- ЦЕГ-ын даргын 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/246 дугаар тушаалаар батлагдсан “Зарим хөтөлбөр, төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх журам” /код 109/:

- 109.3. Цагдаа, дотоодын цэргийн байгууллага нь Терроризмтой тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т зааснаар терроризмоос сэргийлэх арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөнд нийцүүлэн өөрийн байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх төлөвлөгөө батлан хэрэгжүүлнэ.

- 109.4.1.Цагдаа, дотоодын цэргийн байгууллага нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн 8.1-д заасан гамшгаас хамгаалах төлөвлөгөө гарган хэрэгжүүлнэ.

- 109.4.2.Цагдаа, дотоодын цэргийн нийт байгууллагын хэмжээнд хэрэгжих төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавих үүргийг цагдаагийн төв байгууллагын Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба, Дотоодын цэргийн штабын дарга тус тус хүлээнэ.⁸

Энэхүү журамд терроризмтой тэмцэх болон гамшгаас хамгаалахад цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагууд хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан байна.

- ЦЕГ-ын даргын 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/246 дугаар тушаалаар батлагдсан “Гамшиг, галын аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх журам” /код 126/:

- 126.2.1.Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын дарга, алба хаагч, ажиллагсад нь галын аюулаас урьдчилан сэргийлэх болон гал унтраах дүрэм, журам, стандартыг хангаж ажиллах үүрэг хүлээнэ.⁹

- ЦЕГ-ын даргын 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/246 дугаар тушаалаар батлагдсан “Байгууллагын даргын тушаал гаргах журам” /код 136/:

- 136.2.2.Байгууллагын даргын тушаал нь Монгол Улсын Үндсэн хууль, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Дотоодын цэргийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Архивын тухай хууль, Захиргааны ерөнхий хууль болон бусад холбогдох хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан эрх зүйн актыг үйл ажиллагаандаа баримтална.¹⁰

- ЦЕГ-ын даргын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/264 дүгээр тушаалаар батлагдсан “Цагдаагийн эргүүл, харуулын дүрмийг хэрэгжүүлэх журам” /код 401/:

- 401.3.3.Эргүүлд цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагч, олон нийтийн цагдаа, иргэдийн туслалцааг авч болно. Энэ тохиолдолд дангаар үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.¹¹

Энэхүү журмаар эргүүл, харуулын үүрэг гүйцэх үед цагдаа, дотоодын цэргийн алба хаагчид харилцан, хамтран ажиллах, дотоодын цэрэг дангаар эргүүлийн үүрэг гүйцэтгэхгүй байхтай холбоотой харилцааг зохицуулжээ.

- ЦЕГ-ын даргын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/265 дугаар тушаалаар батлагдсан “Дипломат төлөөлөгчийн газар, улсын онц чухал объектын харуул, хамгаалалтыг зохион байгуулах журам” /код 501/:

- 501.2.1.Монгол Улсын Засгийн газраас цагдаа, дотоод цэргийн байгууллагын хамгаалалтанд байхаар тогтоосон дипломат төлөөлөгчийн газар, улсын онц чухал объект /

⁸ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. УБ.2018. 62 тал

⁹ Мөн бүтээл. 213 дахь тал

¹⁰ Мөн бүтээл. 289 дэх тал

¹¹ Мөн бүтээл. 571 дэх тал

цаашид “объект” гэх/-ын харуул, хамгаалалтыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

- 501.2.2.Байгууллага, алба хаагч нь үйл ажиллагаандаа Цагдаагийн албаны тухай хууль, Дотоодын цэргийн тухай хууль, НҮБ-ын Дипломат харилцааны тухай 1961 оны Венийн конвенци, “Цагдаагийн байгууллагын дотоод албаны дүрэм”, “Цагдаагийн эргүүл, харуулын дүрэм” болон бусад эрх зүйн актыг баримтална.

- 501.2.3.Монгол Улсын Засгийн газрын тогтоол, шийдвэрийг удирдлага болгож, Цагдаагийн төв байгууллага, дотоодын цэрэг, Гадаад харилцааны яам, Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтран дипломат төлөөлөгчийн газар, Элчин сайдын яам, улсын онц чухал объектыг хамгаалах, хамгаалалтыг зохион байгуулж, тэнд ажиллах хүн хүч, орон тоо, цалин бусад хангамжийн асуудлыг шийдвэрлэнэ.¹²

• ЦЕГ-ын даргын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/265 дугаар тушаалаар батлагдсан “Онц байдал зарласан үед нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах журам” /код 505/:

- 505.3. /Цагдаагийн байгууллагаас гүйцэтгэх үүрэг/-ийн б/цагдаа, дотоодын цэргийн хүч хэрэгслийг бүрэн ашиглах;¹³

Энэхүү журмаар онц байдал зарласан үед цагдаа, дотоодын цэргийн харилцан, хамтын ажиллагаа зохицуулагдана. Цагдаагийн ерөнхий газрын дарга бол Дотоодын цэргийн командлагч бөгөөд олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд цагдаагийн байгууллагын хүч хэрэгсэл хүрэхгүй тохиолдолд бүрэн дайчлах эрх нь байдаг.

• ЦЕГ-ын даргын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/265 дугаар тушаалаар батлагдсан “Гамшгийн үеийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам” /код 508/:

- 508.4.3.Дотоодын цэргийг байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, хүн, малын гоц халдварт өвчин гарсан үед аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд цагдаагийн байгууллагад дэмжлэг үзүүлэх болон хорио цээрийн дэглэмийг сахиулахад Дотоодын цэргийн командлагчийн шийдвэрээр татан оролцуулж болно.¹⁴

Энэхүү журмаар гамшгийн аюул тохиолдсон үед цагдаагийн байгууллагад дэмжлэг үзүүлэх болон хорио цээрийн дэглэмийг сахиулахад Дотоодын цэргийн командлагчийн шийдвэрээр татан оролцуулж болох эрх зүйн үндэслэлийг тусгажээ.

• ЦЕГ-ын даргын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/265 дугаар тушаалаар батлагдсан “Зорчигч, ачаа тээшийг тээврийн замд харгалзан хүргэх журам” /код 509/:

- 509.2.1. Байгууллага, алба хаагч нь үйл ажиллагаандаа Цагдаагийн албаны тухай хууль, Дотоодын цэргийн тухай хууль, Авто тээврийн тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль, Засгийн газрын 2017 оны 283 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоодын цэргийн алба-ажиллагааны дүрэм”-ийн 11 дүгээр зүйл, Зам, тээвэр, барилга хот байгуулалтын сайдын 2009 оны 188 дугаар тушаалаар баталсан “Хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд аюул, хохирол учруулж болзошгүй ачааг тээвэрлэх журам”, Стандартлал, хэмжил зүйн үндэсний төвийн Зөвлөлийн 2000 оны 119 дүгээр тогтоолоор

¹² Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. УБ.2018. 629 дэх тал

¹³ Мөн бүтээл. 648 дахь тал

¹⁴ Мөн бүтээл. 655 дахь тал

баталсан “Аюултай ачааны стандарт”, “Үйлдвэрлэлээс гаргасан хор аюулын лавлах мэдээллийг үндэслэн аюултай ачаа нэг бүрээр боловсруулж байгаль орчны болон гамшгаас урьдчилан сэргийлэх хяналтын улсын байцаагчийн баталгаажуулсан аюулгүй ажиллагааны заавар”, энэхүү журмыг тус тус баримтална.

- 509.4.4.Зорчигч, ачаа тээшийг түр хамгаалалтад авч, тээврийн замд харгалзан хүргэх ажиллагааг Дотоодын цэргийн штабын дарга /шаардлагатай тохиолдолд цагдаагийн төв байгууллагын дарга, дотоодын цэргийн командлагчийн шийдвэрээр Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны дарга/-ын шийдвэрээр дотоодын цэрэг /нутаг дэвсгэрийн цагдаа/-ийн анги, байгууллагаас томилогдсон харгалзан хүргэх харуулаар гүйцэтгүүлнэ.¹⁵

Энэхүү журмаар Дотоодын цэргийн штаб болон Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны даргын хамтарсан шийдвэрээр зорчигч, ачаа тээшийг түр хамгаалалтад авч, тээврийн замд харгалзан хүргэх ажиллагааг зохицуулж байна. Харин Цагдаагийн албаны тухай хууль дотор дотоодын цэрэгтэй шууд холбоотой зохицуулалт тусгагдаагүй байна.

Дотоодын цэргийн үйл ажиллагааны журамд цагдаагийн байгууллагатай холбоотой дараах зохицуулалт орсон журмууд байна. Үүнд:

- Дотоодын цэргийн командлагчийн 2018 оны 01 дүгээр сарын 16-ны А/02 дугаар тушаалаар батлагдсан “Дотоодын цэргийн чиг үүрэг, эрх хэмжээний журам” /код 100/:

- 1/100.3.2.Цагдаагийн байгууллагаас хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд хүч хэрэгсэл хүрэлцэхгүй тохиолдолд цагдаагийн байгууллагад дэмжлэг үзүүлэх зорилгоор дотоодын цэрэг дараах үүргийг гүйцэтгэнэ:

- а/баяр наадам, жагсаал, цуглаан зэрэг нийтийг хамарсан арга хэмжээний үед нийтийн хэв журмыг сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах;

- б/гудамж, талбай зэрэг олон нийтийн газарт үүссэн нийтийг хамарсан эмх замбараагүй байдлыг таслан зогсоох, иргэний болон төрийн байгууллагын аюулгүй байдал, өмч хөрөнгийг хамгаалах;

- в/гяндан, чанга, онцгой дэглэмтэй хорих анги, цагдан хорих байранд үймээн гарсан үед дэг журам тогтоох;

- г/хорих ангиас оргон зайлсан гэмт этгээдийг баривчлах, сураггүй алга болсон этгээдийг эрж олох талаар цагдаагийн болон хорих байгууллагаас явуулж байгаа нэгдсэн арга хэмжээнд оролцох;

- д/шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах;

- е/гэрч, хохирогчийг хамгаалах;

- ж/сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтныг хуяглан хүргэх;

- з/шаардлагатай тохиолдолд хууль тогтоомжоор болон эрх бүхий байгууллагаас тогтоосон нийтээр дагаж мөрдөх журмыг сахиулах зорилгоор явуулж байгаа цагдаагийн байгууллагын эргүүлийн үйл ажиллагаанд оролцох¹⁶.

- 100.3.10.Дотоодын цэрэг нь цагдаагийн байгууллагатай хамтран террорист үйлдлийг таслан зогсоох тусгай ажиллагааны бүсийг хамгаалалтад авах, тухайн бүсэд байгаа иргэний амь нас, эрүүл мэндийг авран хамгаалах, гэмт этгээдийг олж тогтоох, аюулгүй болгох, баривчлах үүргийг гүйцэтгэнэ.

¹⁵Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. УБ.2018. 659 дэх тал

¹⁶Дотоодын цэргийн үйл ажиллагааны журам. УБ.2019. 5 дахь тал

- 100.3.10.Дотоодын цэрэг нь улсын онц чухал объектыг хамгаалах, аврах, хорио цээрийн дэглэмийг сахиулахад оролцох, ачаа тээшийг харгалзан хүргэх, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болсон үед иргэний болон төрийн байгууллагын аюулгүй байдал, өмч хөрөнгийг хамгаалахад дэмжлэг үзүүлэх, гяндан, чанга, онцгой дэглэмтэй хорих анги, цагдан хорих байранд үймээн гарсан үед дэг журам тогтооход оролцох, хорих ангиас оргон зайлсан гэмт этгээдийг баривчлах, сураггүй алга болсон этгээдийг эрж олох талаар цагдаагийн болон хорих байгууллагаас явуулж байгаа нэгдсэн арга хэмжээнд оролцох, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах, гэрч, хохирогчийг хамгаалах, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтныг хуяглан хүргэх, их хэмжээний үнэт зүйл, мөнгөн тэмдэгт, цацраг идэвхт үүсгүүр, химийн хорт бодис, эсхүл хүний амь нас, эрүүл мэнд, байгаль экологийн тэнцвэрт байдалд шууд хохирол учруулах эрсдэлтэй болон гэмт халдлагад өртөж болзошгүй бусад объектыг түр хугацаагаар хамгаалах, зорчигч, ачаа тээшийг харгалзан хүргэх, цагдаагийн байгууллагатай хамтран террорист үйлдлийг таслан зогсоох тусгай ажиллагааны бүсийг хамгаалалтад авах, тухайн бүсэд байгаа иргэний амь нас, эрүүл мэндийг авран хамгаалах, гэмт этгээдийг олж тогтоох, аюулгүй болгох, баривчлах үүргийг гүйцэтгэх, шаардлагатай тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасан үндэслэл журмын дагуу гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах шийдвэрийг гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэхдээ Цагдаагийн албаны тухай хуулийн холбогдох заалт, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд заасан журмыг баримтална.

100.4.1.Дотоодын цэргийн штаб, анги, байгууллага нь Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмыг үйл ажиллагаандаа мөрдөнө.¹⁷

- Дотоодын цэргийн командлагчийн 2018 оны 01 дүгээр сарын 16-ны А/02 дугаар тушаалаар батлагдсан “Нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргийн таслах зогсоох ажиллагаанд оролцох журам” /код 101/:

- 101.3.1.Дотоодын цэргийн анги, салбаруудыг нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргийн таслах зогсоох ажиллагаанд зөвхөн цагдаагийн байгууллагын хүч хүрэлцэхгүй тохиолдолд Дотоодын цэргийн командлагчийн шийдвэрээр оролцуулна.

- 101.3.2. з/шаардлагатай тохиолдолд хууль тогтоомжоор болон эрх бүхий байгууллагаас тогтоосон нийтээр дагаж мөрдөх журмыг сахиулах зорилгоор явуулж байгаа цагдаагийн байгууллагын эргүүлийн үйл ажиллагаанд оролцох;

- 101.3.7.Дотоодын цэргийн алба хаагч нь бие даан үүрэг гүйцэтгэх шийдвэр гаргахгүй, зөвхөн цагдаагийн алба хаагчид дэмжлэг үзүүлж ажиллана.

- 101.4. и/хариуцаж буй цэгт нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргийн таслах зогсоох чиглэлээр “Шуурхай удирдлагын өгсөн үүргийг хэрэгжүүлэх ажлыг цагдаагийн хүч хэрэгсэлтэй хамтран зохион байгуулах.”¹⁸

- Дотоодын цэргийн командлагчийн 2018 оны 01 дүгээр сарын 16-ны А/02 дугаар тушаалаар батлагдсан “Улсын онц чухал объектын орчны судалгаа хийх журам” /код 210/:

- 210.3.1. Судалгааг нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагатай хамтран ангид штаб, тусгай салбар, салаанд захирагч хийнэ.¹⁹

- Дотоодын цэргийн командлагчийн 2018 оны 01 дүгээр сарын 16-ны А/02 дугаар тушаалаар батлагдсан “Улсын онц чухал объектод гадаадын иргэн нэвтрүүлэх, хяналт тавих, хамтран ажиллах журам” /код 211/:

¹⁷ Дотоодын цэргийн үйл ажиллагааны журам. УБ.2019. 7 дахь тал

¹⁸ Мөн бүтээл 9 дэх тал

¹⁹ Мөн бүтээл 69 дэх тал

- 211.4.1.Дотоодын цэргийн штабын Харуул хамгаалалтын хэлтэс нь улсын онц чухал объектод гадаадын иргэнийг нэвтрүүлэх талаар байгууллага, аж ахуйн нэгжээс ирүүлсэн хүсэлт, түүнд холбогдох материал /албан бичиг, паспорт болон Монгол Улсын эрх бүхий байгууллагаас олгосон түр оршин суух үнэмлэх, визийн хуулбар/-тай танилцаж, мэдээллийг хуулбарлан Эрүүгийн цагдаагийн албанд хүргүүлэн, зохих зөвшөөрлийг гаргуулан авсны дараа тухайн иргэнийг нэвтрүүлэх талаар тус объектыг хамгаалж буй анги, байгууллагад албан бичгээр чиглэл өгнө.Улсын онц чухал объектод гадаадын иргэн нэвтрүүлэх, хяналт тавих, хамтран ажиллах²⁰

Дотоодын цэргийн үйл ажиллагааны журамд заасан үүргийг Цагдаагийн албаны тухай хуульд заасан олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй харьцуулан авч үзвэл:

Дотоодын цэргийн үйл ажиллагааны журмын 100.3.2	Цагдаагийн албаны тухай хуулийн 10-12 дугаар зүйл
а/баяр наадам, жагсаал, цуглаан зэрэг нийтийг хамарсан арга хэмжээний үед нийтийн хэв журмыг сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах;	12.1.7.нийтийг хамарсан арга хэмжээ, жагсаал, цуглааны үеийн хамгаалалт хийх;
б/гудамж, талбай зэрэг олон нийтийн газарт үүссэн нийтийг хамарсан эмх замбараагүй байдлыг таслан зогсоох, иргэний болон төрийн байгууллагын аюулгүй байдал, өмч хөрөнгийг хамгаалах;	12.1.1.нийтийн эмх замбараагүй байдал үүссэн, террорист халдлага гарсан, онц болон дайны байдал зарласан үед дэг журам сахиулах, эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх бүх талын арга хэмжээ авах;
в/гяндан, чанга, онцгой дэглэмтэй хорих анги, цагдан хорих байранд үймээн гарсан үед дэг журам тогтоох;	
г/хорих ангиас оргон зайлсан гэмт этгээдийг баривчлах, сураггүй алга болсон этгээдийг эрж олох талаар цагдаагийн болон хорих байгууллагаас явуулж байгаа нэгдсэн арга хэмжээнд оролцох;	10.1.7.хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлсан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, гэмт хэрэг үйлдсэнд сэрдэгдсэн хүнийг эрэн сурвалжлах, баривчлах;
д/шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах;	10.1.9.шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах;
е/гэрч, хохирогчийг хамгаалах;	10.1.8.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасны дагуу гэрч, хохирогчийг хамгаалах;
ж/сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтныг хуяглан хүргэх;	12.1.8.яллагдагч, шүүгдэгч, ялтныг цагдан хорих байрнаас шүүх хуралдаанд, шүүх хуралдаанаас цагдан хорих байранд хуяглан хүргэх.
з/шаардлагатай тохиолдолд хууль тогтоомжоор болон эрх бүхий байгууллагаас тогтоосон нийтээр дагаж мөрдөх журмыг сахиулах зорилгоор явуулж байгаа цагдаагийн байгууллагын эргүүлийн үйл ажиллагаанд оролцох	11.1.2.гудамж, талбай болон нийтийн эзэмшлийн бусад газарт эргүүл хийх, байнгын болон түр ажиллагаатай хянаж-нэвтрүүлэх цэг ажиллуулах дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, бусад арга, техник хэрэгсэл ашиглан хяналт тавих; ²¹

Дотоодын цэргийн үйл ажиллагааны журамд заасан Цагдаагийн байгууллагаас хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд хүч хэрэгсэл хүрэлцэхгүй тохиолдолд цагдаагийн байгууллагад дэмжлэг үзүүлэх зорилготой дотоодын цэргийн гүйцэтгэх үүргийг Цагдаагийн албаны тухай хуульд заасан чиг үүрэгтэй харьцуулан авч үзлээ.

Энэхүү харьцуулалтаас үзвэл Цагдаагийн албаны тухай хуульд заасан чиг үүрэгтэй Дотоодын цэргийн командлагчийн 2018 оны 01 дүгээр сарын 16-ны А/02 дугаар тушаалаар батлагдсан “Дотоодын цэргийн чиг үүрэг, эрх хэмжээний журам” /код 100/-ын 1/100.3.2-д заасан гүйцэтгэх үүрэгтэй агуулгын хувьд нэг байгаа нь харилцан, хамтран ажиллах үйл ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлж байна.

Цагдаагийн албаны тухай хуульд гяндан, чанга, онцгой дэглэмтэй хорих анги, цагдан хорих байранд үймээн гарсан үед дэг журам тогтоохтой холбоотой үүрэг болон эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

Харин Онц байдлын тухай хуулийн 12 дугаар зүйл /Онцгой нөхцөл, түүний үр дагаврыг арилгахад цэргийн зарим анги, байгууллагыг татан оролцуулах/-ийн 12.1. “Энэ

²⁰ Дотоодын цэргийн үйл ажиллагааны журам. УБ.2019. 70 дахь тал

²¹ Төрийн мэдээлэл. 2017. №6. Цагдаагийн албаны тухай хууль

хуулийн 4 дүгээр зүйлд заасан онцгой нөхцөл, түүний үр дагаврыг арилгах, нийгмийн амьдралыг хэвийн болгоход төрийн болон нутгийн захиргааны, онцгой байдал, дотоодын цэргийн болон цагдаагийн байгууллагын хүч хэрэгсэл хүрэлцэхгүй байгаа тохиолдолд дор дурдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд зэвсэгт хүчин, хилийн цэргийн зарим анги, байгууллагыг татан оролцуулж болно”²² гэсэн зохицуулалт нь цагдаа, дотоодын цэргийн хамтын ажиллагааны эрх зүйн нэг үндсийг тодорхой болгосон зохицуулалт болж байна.

Дүгнэлт. Цагдаа, дотоодын цэргийн хамтын ажиллагааны эрх зүйн үндэс нь Дотоодын цэргийн тухай, Онц байдлын тухай хууль, Цагдаагийн болон Дотоодын цэргийн үйл ажиллагааны журам, ЦЕГ-ын дарга, Дотоодын цэргийн командлагчийн шийдвэр, түүнтэй нийцүүлэн гаргасан бусад актаар тодорхойлогдож байна.

Харин Цагдаагийн албаны тухай хуульд дотоодын цэрэгтэй хамтын ажиллагааны талаар тусгайлан заасан зохицуулалт тусгагдаагүй байгаа нь эрх зүйн үндэс бүрэн зохицуулагдсан гэж үзэхэд учир дутагдалтай гэж үзэхэд хүргэж байна. Тиймээс Цагдаагийн албаны тухай хууль болон бусад эрх зүйн актад энэ талын зохицуулалтыг тусгайлан оруулж өгөх нь зөв гэж үзэж байна.

Санал. Дээрхи дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Цагдаагийн албаны тухай хуулийн 12.3-д “Нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргийн таслах зогсоох ажиллагаанд цагдаагийн байгууллагын хүч хүрэлцэхгүй тохиолдолд зөвхөн Дотоодын цэргийн командлагчийн шийдвэрээр дотоодын цэргийн анги, салбаруудыг оролцуулна” гэсэн зохицуулалтыг шинээр нэмж оруулах;

2. ЦЕГ-ын даргын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/265 дугаар тушаалаар батлагдсан “Жагсаал, цуглааныг албадан тараах журам” /код 503/-ын 503.4.8-д “Жагсаал, цуглааныг албадан тараах ажиллагаанд цагдаагийн байгууллагын хүч хүрэлцэхгүй тохиолдолд Дотоодын цэргийн командлагчийн шийдвэрээр дотоодын цэргийн анги, салбаруудыг оролцуулна” гэсэн заалтыг шинээр нэмж оруулах;

3. ЦЕГ-ын даргын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/265 дугаар тушаалаар батлагдсан “Нийтийн эмх замбараагүй байдал үүссэн үед олон нийтийн аюулгүй байдлыг хангах журам” /код 504/-ын 504.3.4-д “Нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох ажиллагаанд цагдаагийн байгууллагын хүч хүрэлцэхгүй тохиолдолд Дотоодын цэргийн командлагчийн шийдвэрээр дотоодын цэргийн анги, салбаруудыг татан оролцуулна” гэсэн заалтыг шинээр нэмж оруулах;

²² Төрийн мэдээлэл. 1996. №2 Онц байдлын тухай хууль

Ашигласан материал

Монгол Улсын хууль тогтоомж:

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Цагдаагийн албаны тухай хууль
3. Дотоодын цэргийн тухай хууль
4. Үндэсний аюулгүй байдлын тухай хууль
5. Онц байдлын тухай хууль

Ном, сурах бичиг, гарын авлага:

6. Б. Баянмөнх Цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа. УБ.2018.
7. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. УБ.2018
8. Дотоодын цэргийн үйл ажиллагааны журам. УБ.2019

Сонин сэтгүүл:

9. Төрийн мэдээлэл. 1992. №1.
10. Төрийн мэдээлэл. 1996. №2
11. Төрийн мэдээлэл. 2017. №6.
12. Төрийн мэдээлэл. 2017. №12